

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ



Аялал жуулчлалын гол чиглэл дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолборууд байгуулагдана

Монгол Улсад анх удаа олон улсын жишигт нийцсэн, стандартын шаардлага хангасан үйлчилгээний цогцолборууд аялал жуулчлалын гол чиглэл, олон улс, улсын чанартай авто зам дагуу шинээр байгуулагдсанаар гадаад, дотоод аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын ая тухтай, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зэрэг ач холбогдолтой.

үйлчилгээний байгуулах бөгөөд аж ахуйн нэгжүүдийг бусад байршлуудад саналаа ирүүлэхийг урьж байна.



Нийт 35 байршилд түр буудаллах цэг,



“Татварын ёс зүй”–н талаар хэлэлцүүлэг өрнүүллээ

байцаагчид хамтарсан “Татварын ёс зүй” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг “Бизнесийн ёс зүйн төв”, “Монгол Такс ТМЗ” ХХК хамтран зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт Татварын Ерөнхий Газар, Татварын Мэргэшсэн Зөвлөхийн Нийгэмлэг, МҮХАҮТ-ын гишүүн ААН-ууд болон нийт 100 гаруй бизнес эрхлэгч нарын төлөөлөл оролцож, Татварын Ёс Зүйтэй Бизнес Эрхлэхүйг Төлөвшүүлэ манлайлалд нэгдэхээ илэрхийлэв.



Татварын ажилтны мэргэжлийн ёс зүй, татварын ёс суртахууны тухай болон татварын хуулийн хэрэгжилтийн талаар салбарын мэргэшсэн нягтлан, татварын

МҮХАҮТ-ын "ChamberBus" хөтөлбөр эхэллээ



2022 оны "ChamberBus" хөтөлбөр Өмнөговь аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн туршлага судлах бизнес аялал эхэлсэн бөгөөд 4 дүгээр сард Хэнтий, Сүхбаатар аймгийн бизнес эрхлэгчид хөтөлбөрт хамрагдлаа.

Энэ үеэр Монголбанкны Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал, хөрөнгийн зах зээл, финтек ба криптовалют сургалт, Эрдэнэсийн сантай танилцах аялал эрхлэгчид хөтөлбөр МҮХАҮТ-ын үйл ажиллагаа, бодлого, орон нутгийн

бизнесийн орчныг сайжруулах уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсны зэрэгцээ үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй танилцсан юм.

МҮХАҮТ 2016 оноос орон нутгийн салбар танхимын тэргүүлэгч гишүүд болон гишүүн байгууллагуудыг Үндэсний танхимтай танилцуулах, томоохон ААН-ээр айлчилж туршлага судлах “ChamberBus” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ



МҮХАҮТ-ын Дархан Уул аймаг дахь Салбар Танхимын Бүх гишүүдийн V хурал болж, даргаар З.Болорсүвд сонгогдлоо

МҮХАҮТ-ын Дархан Уул аймаг дахь Салбар Танхимын Бүх гишүүдийн V хурал Дархан хотод боллоо.

МҮХАҮТ-ын Дархан Уул аймаг дахь Салбар Танхимын Бүх гишүүдийн V хуралд нийт 80 гаруй бизнес эрхлэгчид оролцсон бөгөөд Салбарын Танхимын тэргүүлэгч гишүүд болон Салбар Танхимын даргыг шинээр сонголоо.

Салбарын танхимын үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаар Салбарын танхимын дарга С.Мэндхүү мэдээлэл өгч, гишүүдийн асуултад хариуллаа. Хурлын дэгийг МҮХАҮТ-ын Гишүүнчлэлийн газрын дарга Ц.Магнайбаатар танилцуулж, Бүх гишүүдийн хурлаар Дархан-Уул аймаг дахь Салбар Танхимын даргаар З.Болорсүвд сонгогдлоо.

"Худалдаа, тээвэр" Орос-Монголын бизнес форум ОХУ-ын Владивосток, Улаан-Үд хотуудад зохион байгуулагдлаа



МҮХАҮТ, ОХУ-ын Приморийн мужийн ХАҮТ-уудын холбоо хамтран "Худалдаа, ложистик: Орос-Монголын ажил хэргийн бизнес форум"-ыг 4 дүгээр сарын 27-нд ОХУ-ын Владивосток хотноо зохион байгууллаа.

Форумд Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

Ө.Энхтүвшин, Приморийн хязгаарын Засгийн газрын дарга Вера Георгиевна Щербина, МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин, Приморийн мужийн Худалдаа аж үйлдвэрийн танхимуудын холбооны ерөнхийлөгч Борис Владимирович Ступницкий болон хоёр улсын бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцов.

Мөн 4 дүгээр сарын 29-нд Буриадын ХАҮТ-тай хамтран Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх, бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Орос-Монголын бизнесийн хамтын ажиллагааны форум"-ыг Улаан-Үд хотноо боллоо.

Форумуудын дараа тээвэр ложистик, гадаад худалдаа, барилгын материал, ноолуур, уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт зэрэг чиглэлүүдээр B2B уулзалтууд зохион байгуулагдаж, хамтын ажиллагааны шинэ боломжуудын талаар санал солилцсон юм.



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ



Приморский мужид Монгол Улсын Худалдааны төлөөлөгчийн газар байгуулагдлаа

ОХУ-ын Владивосток хотод байнгын ажиллагаатай Монгол Улсын Худалдааны төлөөлөгчийн газар нээгдлээ. Нээлтийн арга хэмжээнд Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ө.Энхтүвшин, МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин, Приморийн мужийн Худалдаа аж үйлдвэрийн танхимуудын холбооны ерөнхийлөгч Борис Владимирович Ступницкий, Монгол

Улсаас ОХУ-д суугаа Худалдааны төлөөлөгч С.Түвшинтөр, Приморын хязгаарын Засгийн газрын орлогч даргын үүрэг гүйцэтгэгч В.И. Прокопчук нар оролцлоо.



“Дэлхийн Зөн Монгол” ОУБ болон “Монголын ХөлБөмбөгийн Холбоо” ТББ-тай санамж бичиг байгуулж, хамтын ажиллагаагаа өргөжүүллээ


Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимыг төлөөлж Орлогч дарга Б.Намжилсүрэн, “Монголын ХөлБөмбөгийн Холбоо” ТББ-ыг төлөөлж Ерөнхийлөгч А.Ганбаатар нар хөлбөмбөгийн спортыг бизнес эрхлэгчидтэй холбох олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх Санамж бичиг байгууллаа. Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Хөлбөмбөгийн спортыг байгууллага, аж ахуй нэгжүүдэд таниулан дэлгэрүүлэх, тэдний оролцох

боломжийг хангах, багийн спортын давуу талыг олон нийтэд таниулан сурталчлах зэргээр хамтран ажиллах юм. Түүнчлэн “БИЗНЕС СУР” хөлбөмбөгийн тэмцээн зохион байгуулахаар төлөвлөж байна. МҮХАҮТ-ын Орлогч дарга Б.Намжилсүрэн, “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын Үндэсний захирал Б.Болорцэцэг, “Вишнфанд” ББСБ-ын санхүүгийн захирал Б.Цэнгүүн нар Харилцан ойлголцлын санамж бичиг



байгууллаа. Хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, чадавхжуулах, жижиг, бичил бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадварыг

сайжруулахад дэмжлэг үзүүлэх, тэдний дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх, нөлөөллийг нэмэгдүүлэх, бизнес хоорондын хамтын ажиллагааны сүлжээг өргөжүүлэхэд харилцан ашигтай түншлэлийг хөгжүүлэхийг зорьж байна.



SME⁵ | 2022
ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН ОЛОН УЛСЫН
ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА
2022.05.19-22

Хөнгөн Аж Үйлдвэр
ХАА, Газар тариалан
Хүнс

24th ANNUAL TRADE FAIR AND EXHIBITION

Үндэсний үйлдвэрлэгчид
ОУ-ын Брэнд бүтээгдэхүүн
Банк санхүү, Мэдээллийн технологи

ПЛАТИНИУМ ХАМТРАГЧИ | **ТАНЫ ОРОН ЗАЙ**

ГОУЛД ХАМТРАГЧИ | **ТАНЫ ОРОН ЗАЙ**